

38

**ГОВИЙН ӨНДӨР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 4 дүгээр сарын 30

Дугаар

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар үүрэг, 8-р хороо, 11-р хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 Финтек оффис (Fintech office) 4 –р давхарын хурлын танхимд эхэлж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн №1/7 шийдвэрийн дагуу компанийн гүйцэтгэх захирал П.Эрдэнэнцэцэг даргалав.

П.Эрдэнэнцэцэг: 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ТУЗ-ийн хурлын тогтоолын дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж байна. ХЭХ-ын Тооллогын комиссын дарга П.Эрдэнэнцэцэг хуралд оролцогчдын ирцийн талаар танилцуулна.

П.Эрдэнэнцэцэг: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Говийн өндөр компани /190491/, П.Эрдэнэнцэцэг /167595/, П.Батбаяр /.../ П.Эрдэнэчимэг /161501/, Ц.Баярсайхан /33656/ нарын 4 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн байна.

Хуралд оролцогчдын нийт хувьцааны тоо 182501 ширхэг буюу 96.1%

П.Эрдэнэнцэцэг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц Компаний тухай хуулийн 69.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг эхлүүлж, тус хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хувьцаа эзэмшигчдээ хурлын зар, хэлэлцэх асуудлын талаар тодорхой танилцуулга, мэдээллийг хүргүүлэн ажилласан билээ.

Иймд ХЭХ-аар хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцсэн нь: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Танилцуулсан нь:

Нягтлан бодогч Ш.Долгормаа: - "Говийн Өндөр" компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх танилцуулав. Та бүхэнд тайлан тараан өгсөн.

Хэлэлцсэн нь: 2018 оны компанийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах тухай.

Нягтлан бодогч Ш.Долгормаа: Санхүүгийн тайлангийн хувьд асууж, тодруулах зүйл байна уу?

П. Эрдэнэнцэцэг: Асууж тодруулах зүйлгүй. Дэмжиж байна.

П. Батбаяр: Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд асууж тодруулах зүйлгүй. Асуудлыг дэмжиж байна

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 100%-ийн саналаар батлав.

Танилцуулсан нь: Нягтлан бодогч Ш.Долгормаа: - "Говийн Өндөр" компанийн 2018 оны компанийн бизнес төлөвлөгөөг танилцуулав. Та бүхэнд төлөвлөгөөг тараан өгсөн.

Хэлэлцсэн нь:

Нягтлан бодогч Ш.Долгормаа: Төлөвлөгөөтэй холбоотой асуух зүйл байна уу.
П. Эрдэнэцэцэг: Асууж тодруулах зүйлгүй. Дэмжиж байна.
П. Батбаяр: Хэлэлцэх асуудлыг дэмжиж байна
ШИЙДВЭРЛЭСЭН нь: 100%-ийн саналаар батлав.

Хэлэлцсэн нь: Нэмж хувьцаа гаргах тухай, хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай.

Танилцуулсан нь: П.Эрдэнэцэцэг-"Говийн Өндөр " компанийн нэмж хувьцаа гаргах тухай, хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай асуудал дээр гүйцэтгэх захирал П.Батбаяр манай компанийн хувьд нэмж хувьцаа гаргах тухай хэлэлцэж одоогоор компанийн нэмж хувьцаа гаргах боломжгүй энэ асуудлыг түр хойшлуулах хүсэлттэй байна. Компанийн хувьд нэмж хувьцаа гаргах асуудлыг дахин хэлэлцэх болно.

Хэлэлцсэн нь: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг батлах тухай.

Танилцуулсан нь: П.Эрдэнэцэцэг-"Говийн Өндөр " компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг батлах тухай.

Компанийн тухай хууль болон дүрэмд нийцүүлэн дүрэмд өөрчлөлт оруулсан болно.

Хэлэлцсэн нь: ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (энгийн аргаар болон кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох;

Танилцуулсан нь: "Говийн Өндөр" компанийн гүйцэтгэх захирал,

Та бүхэнд тараагдсан хурлын материалд Нэр дэвшигчдийн мэдээлэл тусгагдсан бөгөөд дахин нэг удаа бүх нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулья.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохтой холбоотой асуулт тавигдаагүй бөгөөд энэ чиглэлээр санал гараагүй болно.

За, асуулт байхгүй бол одоо гарах шийдвэрийн төслийг та нөхдөд танилцуулья.

Хуралдааны үндсэн хэсэг өндөрлөж тооллогын комиссын дарга хуралд оролцогчдод саналын хуудас бөглөх зөвлөмж өгөв.

Санал тооллох ажиллагааг тооллогын комисс эхлүүлэв.

Тооллогын комиссын дарга Б.Цацрал: Санал хураалтын үр дүнг хуралд оролцогчдод тооллогын комиссоос танилцуулья.

1-р асуудлыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100%-н саналаар зөвшөөрсөн байна.

2-р асуудал буюу ТУЗ-н ердийн гишүүдээр

П.Эрдэнэцэцэг	хувьцаа эзэмшигчдийн	16.67 % санал
П.Батбаяр	хувьцаа эзэмшигчдийн	16.67 % санал
П.Эрдэнэчимэг	хувьцаа эзэмшигчдийн	16.67 % санал
П.Түмэнбаяр	хувьцаа эзэмшигчдийн	16.67 % санал
П.Ишдорж	хувьцаа эзэмшигчдийн	16.67 % санал

П.Рэнцэнхорол хувьцаа эзэмшигчдийн 16.67 % санал

Хараат бус гишүүнээр:

<u>С.Булган</u>	хувьцаа эзэмшигчдийн	<u>33.33%</u>	санал		
<u>Д.Отгонбаяр</u>	хувьцаа эзэмшигчдийн	<u>33.33%</u>	санал		
<u>Э.Чойхүү</u>	хувьцаа эзэмшигчдийн	<u>33.33%</u>	саналаар	тус	тус

сонгогдов.

3-р асуудал буюу сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлийг батлах тухай асуудлаар хуралд оролцож байгаа сонирхолын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн саналаар уг асуудлыг батлав.


Хурлын тэмдэглэлд тооллогын комиссын тогтоол, саналын хуудас хавсаргав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал мөн өдрийн 12:00 цагт өндөрлөв.

тэмдэглэл хөтөлсөн

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН

ХУРЛЫН ДАРГА



П.Эрдэнэнцэцэг